

ТАНИЛЦУУЛГА

Хүний эрхийн төлөв байдлын талаар
Үндэсний илтгэл бэлтгэх тухай

Нэг. Ерөнхий зүйл

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2006 оны 3 дугаар сарын 15-ний өдөр 60/251 тоот тогтоол баталж, НҮБ-ын бүх гишүүн орны (192 улс) хүний эрхийн төлөв байдлын талаарх тайлан илтгэлийг 4 жил тутамд нэг удаа НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлөөр хэлэлцэж, зөвлөмж өгч байхаар шийдвэрлэсэн билээ.

Дээрх шийдвэрийн дагуу Хүний эрхийн Зөвлөл нь 2007 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр улс орнуудын хүний эрхийн төлөв байдлын талаарх илтгэлийг хэлэлцэх цаг хугацааны хуанли/товыг батлан гаргажээ. Жилдээ Хүний эрхийн Зөвлөлийн чуулганыг 3 удаа хийж, 48 улсын үндэсний илтгэлийг хэлэлцэж, 2011 он гэхэд НҮБ-ын бүх гишүүн орны илтгэлийг хэлэлцсэн байхаар төлөвлөөд байна. Уг шийдвэрийн дагуу эдүгээ (2009.05.01-ний байдлаар) 64 улсын хүний эрхийн төлөв байдлын талаархи илтгэлийг хэлэлцсэн бөгөөд Монгол Улс Үндэсний илтгэлээ 2010 онд хэлэлцүүлэх юм.

НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлийг 2006 онд Хүний эрхийн Комиссын суурин дээр үндэслэн 47 гишүүнтэйгээр байгуулсан болно. Хүний эрхийн Зөвлөл нь дараахь үндсэн баримт бичгүүдийн хүрээнд улс орны хүний эрхийн байдлын талаарх илтгэлийг хэлэлцдэг. Үүнд:

1. НҮБ-ын Дүрмийн заалт;
2. Хүний эрхийн Түгээмэл тунхаглал;
3. Тухайн улс орны нэгдэн орсон олон талт конвенц, гэрээ хэлэлцээр;
4. Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн холбогдох баримт бичиг, эдгээр болно.

Хоёр. Илтгэл бэлтгэх, хэлэлцэх журам

НҮБ-ын бүх гишүүн орны хувьд Хүний эрхийн Зөвлөл өөрийн Ажлын хэсгийн хуралдаанаар үндсэн 3 илтгэлийг хэлэлцдэг.

а/ Тухайн улсын **Үндэсний илтгэл**. Тус илтгэлийг Засгийн газар бэлтгэх бөгөөд илтгэлд хүний эрхийг хамгаалах чиглэлээр олсон ахиц амжилт, тохиолдож буй бэрхшээл, тэргүүн ач холбогдол өгч буй асуудал, хэрэгжүүлэх арга замын талаар

тусгаж өгнө. **Хэмжээний хувьд 10700 англи үгэнд багтаан, 20 хуудсаас хэтрүүлэхгүй байх ёстой.**

б/ Хүний эрхийн асуудлаархи НҮБ-ын баримт бичигт тусгагдсан илтгэл бэлтгэдэг байгууллагууд, хүний эрхийн асуудлаархи тусгай илтгэгч нарын байр суурийг тусгасан **хөндлөнгийн илтгэл**. Тус илтгэлийг Хүний эрхийн Дээд комиссарын газраас бэлтгэнэ. Илтгэлийг 5380 англи үгэнд багтаан, **10 хуудсаас хэтрүүлэхгүйгээр бэлтгэнэ.**

в/ Хүний эрхийн асуудлаархи төрийн бус байгууллагууд зэрэг сонирхсон бусад талын **хөндлөнгийн илтгэл**. Тус илтгэлийг Хүний эрхийн Дээд комиссарын газраас эрхлэн 5380 англи үгэнд багтаан, 10 хуудаснаас хэтрүүлэхгүйгээр бэлтгэнэ.

Аль ч улс орны Үндэсний Илтгэлийг 3 үе шаттайгаар авч хэлэлцэнэ.

а/ Эхний шатанд Хүний эрхийн Зөвлөлийн нарийн бичгийн дарга нарын газар улс орны Үндэсний илтгэлийг хүлээн авч, хэлэлцэх бэлтгэлийг хангана.

б/ Хоёр дахь шатанд буюу 13 долоо хоногийн дараагаар Хүний эрхийн Зөвлөлийн Ажлын хэсэг (Зөвлөлийн дарга, гишүүн 47 улс, НҮБ-ын гишүүн ажиглагч, сонирхсон бусад талууд багтана) Женев хотноо хуралдаж илтгэлийг 3 цагт багтаан хэлэлцэнэ. Илтгэлээ хэлэлцүүлэн буй улсын төлөөлөгч нэг цагт багтаан товч танилцуулга хийж, тавьсан асуултад хариу өгөх, дүгнэлт хийх журамтай. Нөгөө 2 цагт нь Ажлын хэсгийн гишүүн, ажиглагч нар илтгэлтэй холбогдуулан байр суурь, саналаа хэлж, зөвлөмж өгөх боломжтой.

в/ Гурав дахь буюу эцсийн шатанд, Хүний эрхийн Зөвлөлийн нэгдсэн хуралдааныг Ажлын хэсгийн хуралдаанаас хойш 3 сарын дараагаар Женев хотноо зохион байгуулж, үндэсний илтгэлийг авч хэлэлцсэн байдлыг дүгнэн, зөвлөмжийг батлан гаргана. Ийм хуралдааныг 60 минут буюу нэг цагт багтаан явуулна. Илтгэлээ хэлэлцүүлж байгаа улсын төлөөлөгч нь 20 минутад багтаан Ажлын хэсгийн үеэр хариулаагүй үлдээсэн асуулт байвал хариулт өгөх, улс гүрнүүдээс өгч буй зөвлөмжийн талаар байр сууриа илэрхийлэх, дүгнэлт хийх учиртай.

Нэгдсэн хуралдааны үеэр гаргах Хүний эрхийн Зөвлөмжийн талаар санал хураалт явагдахгүй, Зөвлөл шийдвэрээ нийтийн тохиролцоогоор (консенсус) баталдаг журамтай ажээ.

Гурав. Үндэсний илтгэлийг бэлтгэхэд анхаарах зүйл

